



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/672

Булган сум

Г Газар эзэмших эрхийн гэрчилгээний Г
хугацаа сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Магнай трейд” ХХК /РД:2082489/-ийн шатахуун түгээх станцын зориулалтаар эзэмшиж буй Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 4 дүгээр гудамж 411 тоотод байршилтай 6308007344 нэгж талбарын дугаар бүхий 3000 м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилээр сунгасугай.

2.“Магнай трейд” ХХК-д Булган сумын шинэчилсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг танилцуулж, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчилж, газар ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг “Магнай трейд” ХХК-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ